



85

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 12 сарын 13 өдөр


Дугаар 472

Улаанбаатар хот

Г Удирдамж батлах тухай Г

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, Эрүүл мэндийн сайдын 2012 оны 272 дугаар тушаалаар батлагдсан “Сувилахуйн тусlamж, үйлчилгээг хөгжүүлэх стратеги-ийн хэрэгжилтийг хангах, сувилахуйн тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Гэрээр үзүүлэх сувилахуйн тусlamж, үйлчилгээний удирдамж”-ийг нэгдүгээр, “Сувилгааны газарт үзүүлэх сувилахуйн тусlamж, үйлчилгээний удирдамж”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан удирдамжийг тусlamж, үйлчилгээнд нэвтрүүлж, мөрдлөг болгон ажиллахыг бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү удирдамжийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Я.Буянжаргал)-т, Эрүүл мэндийн яамны дэргэдэх сувилахуйн мэргэжлийн салбар зөвлөл (Д.Солонго)-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтуюя)-д даалгасугай.



003003

Эрүүл мэндийн сайдын
2013 оны 12 сарын 13-өдрийн
470 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

ГЭРЭЭР ҮЗҮҮЛЭХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УДИРДАМЖ

1. Товчилсон үгийн жагсаалт:

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ЕБС	Ерөнхий боловсролын сургуул
НЭМС	Нийгмийн эрүүл мэндийн сувилахуй
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
APRN	Advanced Practice Registered Nurse
NANDA	North American Nursing Diagnostic Association
PhD	Philosophy of Doctor
RN	Registered Nurse

2. Өмнөх үг

Эрүүл аж төрөх нь хүн бүрийн чин хүслэн бөгөөд сувилахуйн тусlamж, үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлж буй дэлхийн зарим улс орны чиг хандлагаас үзвэл өвчтэй хүмүүсийг гэрт нь эмчлэх, түргэн илаарших тав тухтай орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч ирсэн. Ингэж асаргаа, сувилгааг хийхдээ өвчтөн, тэдний ар гэрийнхнийг оролцуулан, цаашид эрүүл мэндээ хэрхэн хамгаалах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх мэдлэг, боловсрол олгох, эрүүл аж төрөхөд нь дэмжиж туслахад чиглэдэг.

Манай орны хувьд, эрүүл мэндээ эмнэлэг, эмчид даатгадаг сэтгэлгээ ард иргэдийн дунд давамгай, эрүүл мэндийн боловсрол, мэдлэг хомс байгаагаас насанд хүрсэн хүмүүсийн ихэнх нь ямар нэгэн өвчин, эмгэгтэй байгаа талаар зарим судалгааны дүн харуулж байна.

3. Оршил

Айл өрхүүд өвчин эмгэгтэй гэр бүлийн гишүүнээ асарч, сувилж, эмчилж ирсэн түүхэн уламжлалтай боловч эмнэлэг олноор байгуулагдаж, эмнэлгээр үзүүлэх тусlamж, үйлчилгээг хөгжүүлэхийн хэрээр гэрийн асаргаа, сувилгааны ач холбогдлыг зэрэгцүүлэн авч явах асуудлыг орхигдуулсан.

АНУ, Канад, Шинэ Зеланд, Австрали болон сувилахуйн шинжлэх ухаан өндөр хөгжсөн бусад оронд гэрийн сувилгааг магистрын түвшинд мэргэшсэн сувилагч (APRN-Advanced Practice Registered Nurse) үзүүлж байна.

Эмнэлгийн нөхцөлд эмчлэх гол үйлчилгээг үзүүлээд бүрэн илаарших хүртэл нь гэрээр сувилах, нөхөн сэргээх тусlamжийг үргэлжлүүлэн, энэ чиглэлээр тусlamж, үйлчилгээг үзүүлдэг бие даасан агентлаг, төв, ажиллуулдаг туршлага өндөр хөгжилтэй орнуудад нийтлэг байна.

Өвчний хүндэвтэр, хүнд хэлбэрийн үед эмнэлгээс бүрэн илааршаагүй гарсан тохиолдолд гэрийн сувилахуйн цогц тусlamж үзүүлж чаддаггүйгээс өвчин архагших, эмнэлэгт давтан хэвтэж, эмнэлгийн ачааллыг нэмэгдүүлэх тохиолдол их байна.

Эмнэлгээс гарч буй өвчтөнийг гэртээ үргэлжлүүлэн эмчлэн, сувилахад мэргэшсэн буюу сувилахуйн тусlamж, үйлчилгээг цогцоор нь үзүүлэх чадварлаг сувилагч, хүний нөөц хангалтгүй байна.

Эрүүл мэндийн сайдын 2004 оны 136 тоот тушаалаар гэрээр үзүүлэх сувилахуйн тусlamжийг өрхийн сувилагч үзүүлнэ гэж заасан байдаг ч өрхийн сувилагч энэхүү үйлчилгээг үзүүлэхэд цаг хугацаа, ажиллах орчин нөхцлийн хувьд хангалтгүй байна.

Түүнчлэн өрхийн эрүүл мэндийн төвийн статус нь зөвхөн анхан шатны тусlamж үзүүлнэ гэсэн нь үйлчлүүлэгчдийн төрөлжсөн мэргэжлийн тусlamж авах хэрэгцээтэй зөрчилддөг.

Монгол орны хувьд гэрийн сувилахуйн тусlamж, үйлчилгээг үзүүлж байгаа байдал, эмнэлгээс гарч байгаа өвчтөн, тэдний эрэлт хэрэгцээнд үндэслэн гэрээр хэрхэн тусlamж үзүүлж байгаа байдалд үнэлгээ өгөх, улмаар сувилагч бэлтгэдэг сургуулиудын хичээлийн хөтөлбөрт энэхүү агуулга хэрхэн туссан талаар хийгдсэн судалгаа хомс байна. Иймд энэ асуудлыг иж бүрэн судалж, өнөөгийн байдалд тодорхой дүгнэлт өгөх асуудал тулгамдаж байна.

Эдгээр асуудал нь гэрээр сувилахуйн тусlamжийг үзүүлэхэд сувилагчийн баримтлах УДИРДАМЖ боловсруулах үндэслэл болсон.


A.ЕРӨНХИЙ ХЭСЭГ

A.1. Онош, хам шинж

Гэрийн сувилахуйн тусlamж: гэдэг нь 1982 онд “McNamara”-гийн тодорхойлсноор “Гамшигт нэрвэгдсэн болон ужиг, хурц өвчтэй бүх насны хүмүүст гэрийн орчинд хэрэгцээтэй байгаа эмчилгээ, асаргаа, сувилгаа болон нэн шаардлагатай, хэрэгцээт үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн цогц үйл ажиллагaa юм”

A.2. Өвчний код

Бүх өвчний үед гэрээр үзүүлж буй сувилахуйн болон багийн эмчийн тусlamж, үйлчилгээний хэсэгт ашиглагдана.



A.3. Удирдамжийг хэрэглэгчид

Удирдамжийг сувилахуйн тусlamж, үйлчилгээг гэрээр үзүүлэх сувилагч, багийн эмч мэргэжилтэн үйл ажиллагаандаа хэрэглэнэ.

A.4. Удирдамжийн зорилт

- Гэрийн нөхцөлд мэргэжлийн сувилахуйн тусlamж, үйлчилгээг тодорхой удирдамжийн дор үзүүлэх нөхцөл бололцоог хангах,
- Тусlamж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эмнэлгийн шаардлагагүй хэвтэлтийг бууруулах,
- Гэрийн сувилагч гэсэн мэргэжилтнийг төгсөлтийн дараах сургалтаар мэргэшүүлэн сургах сургалтын агуулгыг тодорхойлох.

A.5. Удирдамж боловсруулсан он

- Боловсруулсан огноо: 2013 он

A.6. Шинэчлэн засах хугацаа:

Удирдамжийн хэрэгжилтийг эрүүл мэндийн байгууллагууд өөрийн үйл ажиллагааны хүрээнд үнэлэн, нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа ЭМЯ-ны Эмнэлгийн тусlamжийн хэлтэст ирүүлнэ. ЭМЯ-ны Эмнэлгийн тусlamжийн хэлтэс ирүүлсэн саналыг тусган шаардлагатай гэж үзвэл 1-3 жил тутамд шинэчилнэ.

A.7. Удирдамж боловсруулахад оролцсон байгууллага, хүмүүсийн нэр, хаяг

Д.Солонго

ЭМШУИС, Сувилахуйн Сургуулийн Төрөлжсөн

сувилахуйн тэнхмийн эрхлэгч, Сувилахуйн ухааны доктор

С.Наранчимэг

ЭМШУИС, Анааах ухааны сургуулийн ЭЗСУЧ-ийн тэнхмийн эрхлэгч, доктор, дэд профессор Улаанбаатар Сонгдо Эмнэлгийн сувилгааны албаны дарга, ЭМШУИС, НЭМС-ийн магистрант

Л.Дондоосүрэн

Улаанбаатар Их Сургуулийн Сувилахуйн тэнхмийн багш
Сувилахуйн ухааны магистрант

89

Удирдамжийг хэлэлцүүлсэн байдал:

Хэлэлцүүлсэн байдал	Хугацаа/ Давтамж	Бүрэлдэхүүн
Төслийн ажлын хэсгийн хурал	16/V, 15/VI, 27/V, 11/IX, 28/IX, 3/X	Төслийн ажлын багийн хурлаар
Сувилахуйн мэргэжлийн салбар зөвлөлийн хурал	19/VIII, 17/IX	Сувилахуйн Мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүд
ЭМЯ-ны эмнэлгийн тусlamжийн хэлтсийн хурал	4/VII, 27/IX	Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүд
Зөвлөлдөх уулзалт	28/VIII	“Сувилахуйн тусlamж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжрууляя” Тэргүүний сувилагчдын улсын зөвлөгөөн /250 сувилагч/

A.8 Нэр, томьёо, тодорхойлолт, эх сурвалж

A.8.1 Нэр, томьёо

A.8.1.1 Гэрийн сувилгаа: 1796 онд “Dispensary” нэртэй анхны сувилахуйн баг АНУ-ын Бостон хотод байгуулагдаж, ихэвчлэн ядуу хүмүүсийг гэрээр асрах үйл ажиллагаа явуулдаг байсан бөгөөд “Өвчтөнг өөрийн гэр бүлээс нь тусгаарлахгүйгээр, гэрийн орчинд өвчнөөс нь ангижруулж болно” гэсэн гол зарчмыг баримталдаг байсан байна. Энэхүү зарчмыг удирдамжийн гол үндэслэл, тодорхойлолт болгож авч үзлээ.

A.8.1.2 Гэрийн орчин: Амины орон сууц, нийтийн эзэмшлийн орон сууц, нийтийн байр, сувилал, асрамжийн газар, гэр оронгүй хүмүүст бол амь зуулгын оромж гэх мэт орно.

A.8.1.3 Гэрийн сувилагч: Гэрийн нөхцөлд үйлчилүүлэгчид эрүүл мэндийн болон эмнэлгийн тусlamж, үйлчилгээ үзүүлдэг, зөвлөгөө өгдөг, үзүүлж буй тусlamжинд дүгнэлт хийдэг сувилагч-мэргэжилтэнг хэлнэ. /АНУ-ын “Гэрийн сувилгааны сувилагчдын нийгэмлэг”-ийн тодорхойлолт/

A.8.1.4 Гэрээр сувилахуйн тусlamж, үйлчилгээ авах үйлчилүүлэгч гэдэг нь: Гэрийн нөхцөлд, гэр бүлийнхнийхээ дэргэд, өөрийн эрүүл мэндтэй холбоотой тусlamж авч байaa хүн.

A.8.1.5 Гэрийн орчинд түгээмэл илэрдэг асуудлууд, буюу гэрийн сувилахуйд түгээмэл хэрэглэгдэх сувилахуйн онош: Энэхүү оношийг гэрээр тусlamж, үйлчилгээ үзүүлэх сувилагч, үйлчилүүлэгчийн биеийн байдалд үнэлгээ өгч, сувилгааны онош тавихад ашиглана.

1. Гэрийн нөхцөлд цэвэрлэх боломж муутай, цус их гарч байгаа халдварт авах эрсдэл бүхий шархтай;
 2. Бие даан хөдлөх чадваргүй болсон;
 3. Өвчтөн эрүүл мэндийн цогц үйлчилгээ авах шаардлагатай;
 4. Эмчилгээний үр дүн муутай;
 5. Сэтгэл санааны дэмжлэг шаардлагатай, өөрийгөө асрах чадваргүй; ганц бие,
 6. Амьдралын буруу хэв маягтай;
 7. Осол гэмтлийн дараа, цус харвалтын дараах асаргаа, сувилгаа шаардлагатай,
 8. Ар гэр болон хувь хүн нрүүл мэндийн талаарх мэдлэг хомс;
 9. Асран халамжлагч нь өвчтөнийг хэрхэн асрах талаарх мэдлэггүй;
 10. Амьран буй орчин нөхцөл эмх замбараагүй, бохир байх гэх мэт.
- (NANDA-ийн сувилгааны онош:)

A.8.1.6 Сувилгааны үйл ажиллагааны 5 шатлал

Сувилахуйн тусламж нь сувилагч ажлаа зөв, оновчтой зохион байгуулахад чиглэгдсэн тодорхой дэс дараалалтай, хоорондоо уялдаа холбоо бүхий тасралтгүй үргэлжлэх үйл ажиллагаа юм. Энэ нь сувилахуйн тусламж өндөр хөгжсөн орнуудад сувилагчийн ажилдаа баримталдаг гол зарчим юм. Сувилахуйн судлаач, эрдэмтэн Ида Жейн Орландо (Ida Jean Orlando) 1958 онд анх өөрийн ажил, амьдралын практик дээр тулгуурлан энэхүү шатлалыг зохиожээ. Үүнд:

1. Үнэлэх - Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн талаарх мэдээлэл цуглуулах /асуумж авах, ажиглах, бодит үзлэг хийх/
2. Оношлох – Үнэлгээний үндсэн дээр илэрч буй асуудлыг тодорхойлох, илрүүлэх
3. Төлөвлөх- зорилгод хүрэх төлөвлөгөө боловсруулах
4. Хэрэгжүүлэх- төлөвлөгөөг хэрэгжүүлэх, сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэх
5. Дүгнэх- Хийсэн сувилгааны үр дүнг тооцох, дахин үнэлэх зэрэг үйл ажиллагаа орно.

A.8.1.7 Асаргаа, сувилгааны үндсэн зарчим

1. Үйлчлүүлэгчид тав тухтай орчин бүрдүүлэх,
2. Зөв зохистой, эрүүл хооллоход нь туслах,
3. Улирал, нөхцөл байдалд нь тохируулан хувцаслах,
4. Сэтгэл зүйд дэмжлэг үзүүлэх,
5. Тухайн үед илэрч буй шинж, тэмдгийн асаргаа, сувилгаа хийх.

A.8.1.8 Эрүүл мэндийн боловсрол олгох

1. Эрүүл зан үйлийн талаарх мэдлэгийг үнэлэх,
2. Эрүүл аж төрөхөд нь туслах, дэмжих.

A.8.2 Тодорхойлолт

Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ нь “Асаргаа сувилгаа шаардлагатай, бүх насны үйлчлүүлэгчид гэрийн орчинд гэр бүлээс нь тусгаарлахгүйгээр өвчин шаналлаас ангижруулах үйл ажиллагаа.

A.8.3 Мэргэжилтний тодорхойлолт:

Гэрээр тусламж үзүүлэх, мэргэшсэн сувилагч нь дэвшилтэд онол ба шинжлэх ухааны үндэслэлтэй эмнэлзүйн өндөр мэдлэгтэй, эрүүл мэндийн бусад мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах чадвартай, аливаад чин сэтгэлээсээ ханддаг, орчин үеийн мэргэжлийн сувилагчдыг хөгжүүлэхэд манлайлж, практик, судалгаа ба онолыг боловсруулахад зохих хувь нэмрээ оруулах мэргэжилтэн юм.

A.8.4. Эх сурвалж

1. Эрүүл мэндийн сайдын 2004 оны 136 тоот тушаал,
2. Монгол Улсын оношилгоо, эмчилгээний түгээмэл үйлдлийн MNS 4621:2008 стандарт,
3. “Гэрийн нөхцөлд үзүүлж буй сувилахуйн тусламжийг боловсронгуй болгох нь” сэдэвт эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн,
4. Шинэ Зеландийн Окланд хотын “Green Line” эмнэлэг, Тайвань улсын Тайчуунь хотын “China Medical University Hospital”-ын дэргэд ажилладаг Гэрийн сувилгааны нэгж (Home Care Unit) – ийн тогтолцооны загвар

Б. ГЭРЭЭР ҮЗҮҮЛЭХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Б. 1 Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламжийн баг нь дараах төрөлтэй байж болно. Үүнд:

1. Эмнэлгээс томилогдсон гэрээр тусламж, үзүүлэх сувилгааны баг,
2. Өрх, сумын эрүүл мэндийн төвийн сувилагч,
3. Эрүүл мэндийн нэгдлээс томилогдсон гэрийн сувилахуйн баг,
4. Хувийн хэвшлийн гэрийн сувилгааны баг, /өрх, сум, аймаг, дүүргийн эрүүл мэндийн нэгдэлтэй гэрээт байдлаар үйл ажиллагаа явуулах/

Б. 2 Эмнэлгээс томилогдсон гэрийн сувилгааны баг:

Эмнэлэгт хэвтэж байгаа хүмүүс (зарим томоохон мэс засал, тархины цус харвалтын дараа, хавдар өвчний үед) эмнэлгээс бүрэн илааршаагүй гарах үед, эмнэлгийн тасгийн эмч ба ахлах сувилагч “Гэрийн сувилгааны баг”-т үргэлжлүүлэн сувилах хэрэгцээтэй байгаа үйлчлүүлэгчийн захиалгыг өгнө.

Б. 2.1 Гэрийн сувилгааны баг нь тусламж үзүүлж байгаа чиглэлээс хамаарч:

1. “Цус харвалтын дараах сувилгааны баг”
2. “Хавдрын сувилгааны баг”
3. “Эх, хүүхдийн сувилгааны баг”
4. “Хөнгөвчлөх эмчилгээ, сувилгааны баг”

- 92
5. "Мэс заслын дараах сувилгааны баг"
 6. "Наастны сувилгааны баг"
 7. "Гэмтлийн дараах үеийн сувилгааны баг" гэх мэтээр төрөлжсөн сувилахуйн тусlamжийг үзүүлнэ.

Б. 2.2 Өрх, сумын эрүүл мэндийн төв, эрүүл мэндийн нэгдэл, хувийн хэвшлийн гэрийн сувилгааны баг:

Эмнэлэг, өрх, сумын эрүүл мэндийн төвийн хооронд мэдээлэл солилцох үйл ажиллагаа сайн байх ёстой. Үйлчлүүлэгчийн өвчин эмгэгийн талаарх мэдээллийг интернет, дотоод сүлжээ, захиалгын хуудсаар дамжуулан солилцох нь манай орны хувьд боломжтой гэж үзэж байна.

Тухайлбал: Үйлчлүүлэгчийг эмнэлгээс гарахад нь түүний цаашдын асаргаа, сувилгааг гэрээр нь үргэлжлүүлэн хийх талаар зөвшилцөн, захиалгын хуудсыг хамтран үйлдсэн байна. Үйлчлүүлэгчийн тухайн өвчний талаарх мэдээлэл, гэрийн нөхцөлд ямар асаргаа, сувилгаа, эмчилгээ хийх шаардлагатайг гэрийн сувилгааны баг цаг, хугацаа алдалгүй авсан байна. Энэхүү тогтолцоо нь эмнэлгийн ажилтан болон үйлчлүүлэгчийн талаас цаг хугацааг хэмнэсэн, тусlamжийн чанар сайжруулж, төвлөрлийг бууруулахад чиглэгдсэн зөв шийдэл болно.

Б.3 гэрээр сувилахуйн тусlamж, үйлчилгээ үзүүлэх сувилагчийн үйл ажиллагааны дэс дараалал

Б.3.1 Гэрээр тусlamж авах үйлчлүүлэгчийн талаарх мэдээлэлтэй (өвчтөний эмнэл зүйн онош, мэс засал хийлгэсэн эсэх, эмнэлэгт хэвтэж байхдаа ямар эмчилгээ сувилгаа хийлгэж байсан, өвчтний нас, хүйс, одоо амьдарч буй гэр, ахуйн орчин, нөхцөл, боломж,) танилцах;

Б.3.2 Үйлчлүүлэгчтэй холбоо барих (очих цагаа тохирох, хэрэгцээтэй зүйлсийг мэдэж авах);

Б.3.3 Гэрт очихын өмнө хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэхдээ ямар сувилгаа хийхээс хамаарч хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэнэ. (Асаргаа, сувилгааны багажийн иж бүрдэл бүхий цүнх, бичиг баримт, сувилгааны карт);

Б.3.4 Үйлчлүүлэгчийн гэрт очих:

1. Үнэлгээ өгөх, карт хөтлөх;
2. Үйлчлүүлэгчтэй хамтран шийдвэр гаргах;
3. Нэг үйлчлүүлэгчийг эдгэртэл (ямар нэг үр дүнд хүртэл) хэдэн удаа гэрт нь очиж, асаргаа, сувилгаа хийх төлөвлөгөө зохиох;
4. Хуваарийн дагуу сувилгаа хийж, тухай бүр үр дүнг тооцох;
5. Хийсэн бүх ажилбараа сувилгааны картанд бичиж тэмдэглэх;
6. Шаардлагатай тохиолдолд эмч дуудах, багаар ажиллах


Б.4 Гэрийн сувилгааны иж бүрдлийн цунх

Б.4.1 Гэрээр сувилгаа хийхэд хэрэглэгдэх сувилахуйн багаж, төхөөрөмжийн иж бүрдлийг агуулах цунх нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Норох, гэмтэх, гадны таагүй хүчин зүйлүүдээс хамгаалагдсан,
2. Халдвэр тархахаас урьдчилан сэргийлэх боломж бүхий,
3. Цүнхний дотоод зохион байгуулалт нь үйл ажиллагаанаас шалтгаалж таславчтай, ариун, бохир материалыг ангилан хийхэд зориулагдсан тусгаарлагчтай,
4. Угааж, цэвэрлэх, ариутгах, дахин хэрэглэх боломжтой байх,

Б.4.2 Сувилагч гэрийн нөхцөлд сувилахуйн иж бүрдлийн цүнхтэй ажиллахдаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

1. Цүнхнээс хэрэглэгдэх зүйлсийг гаргахын өмнө гарaa угаасан байна,
2. Сувилагч цүнхнээс гаргаж хэрэглэсэн бүх зүйлсийг буцааж цүнхэндээ хийхдээ, ариун, бохир хэсгийн таславчинд ангилан, халдвар дамжихаас сэргийлэх арга хэмжээг авна.
3. Гараа угаанаа,
4. Үйлчлүүлэгчийн гэрт очих бүрт сувилагч цүнх болон гар ариутгагчийг авч явах ёстой,
5. Цүнхийг эмчлүүлэгчийн гэрт аль нэг газар тавихын өмнө жийргэвч уутанд хийнэ,
6. Бүх төрлийн тарилга хийх, биеийн шингэн, өтгөн болон хортой, халдварын эрсдэл бүхий зүйлстэй хүрэлцэхэд бээлий өмссөн байна.



Гэрээр сувилгаа хийхэд авч явдаг цүнхэнд байх материал, багаж хэрэгсэл

Б.4.3 Цүнхэнд зайлшгүй байх материал, тоног төхөөрөмжийн жагсаалт:

1. Даралтын аппарат, чагнуур,
2. Халууны шил,
3. Гар ариутгагч шингэн, шингэн вазелин,
4. Нэг удаагийн бээлий,
5. Шархны цэгцэлгээний ариун материал (багц),
6. Шээлгүүр,
7. Нэг удаагийн тариур,
8. Пульс оксиметр,
9. Дуслын шахуурга,

10. Зарим шинжилгээ авахад шаардлагатай хэрэгсэл /глюкометр, жирэмсний эрт илрүүлэх оношлуур,
11. Антисептик уусмал,
12. Чиг тавьж боох материал,
13. Гар чийдэн,
14. Туузан оношлуурууд
15. Сахар хэмжигч, холестерин хэмжигч, хэл дарагч гэх мэт.

Б.4.4 Тухайн өвчтөнд хийх асаргаа, сувилгааны зорилгоос хамааран нэмэлт материалыг бэлтгэнэ.


B. УЙЛДЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, АРГАЧЛАЛ

В.1 гэрийн сувилахуйн тусlamж, үйлчилгээ үзүүлэхэд хамрагдах үйлчилгээний төрөл

1. Гэрээр сувилахуйн тусlamж авахаар хүсэлт гаргаж, захиалга өгсөн,
2. Өөрийн биеийн ерөнхий байдлыг хянуулахыг хүссэн (даралт үзэх, амьсгал, зүрх судасны лугшилт)
3. Эмнэлэгт удаан хугацаагаар хэвтэн эмчлүүлээд хяналтыг цаашид гэрийн нөхцөлд үргэлжлүүлэх эмчийн заалттай,
4. Мэс заслын дараах асаргаа, сувилгаа,
5. Хавдар өвчний үед хөнгөвчлөх сувилахуй шаардлагатайг эмч нотолсон,
6. Сүрьеэ өвчний үеийн хяналтыг үргэлжүүлэх, эмийг тогтмол уулгаж, биеийн эсэргүүцэл сайжруулах шаардлагатайг эмч нотолсон,
7. Биеийн ерөнхий байдал сайжруулах бүх төрлийн эмийн бус эмчилгээ, нөхөн сэргээх сувилахуйн тусlamж шаардлагатай,
8. Томуу ба томуу төст өвчний үед гэрийн нөхцөлд хийх эмчийн заасан цагийн тарилга болон эмийн ба эмийн бусад эмчилгээ, сувилгаа,
9. Сувилахуйн мэргэжлийн тусlamж үйлчилгээ шаардлагатай өвчтөн. (Харах, асрах хүнгүй өндөр настан, амьдралын түвшин доогуур өрх, тахир дутуу болон эмзэг бүлгийн иргэд)
10. Эрүүл нярайн хяналт, асаргаа, сувилгаа,
11. Жирэмсэн эмэгтэйд тавих хяналт, асаргаа сувилгаа,
12. Бага насны хүүхдэд үзүүлэх сувилахуйн тусlamж (сул сонсголтой, хэл ярианы бэрхшээлтэй болон өсөлтийн сааталтай хүүхдэд дасгал хөдөлгөөн заах, хүүхдийн хоол, тэжээлийн талаар зөвлөгөө өгөх, эцэг эхэд энгийн аргаар шингэн сэлбэх, давсны уусмал бэлдэж уулгахыг аргачлал,
13. Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй насанд хүрсэн хүнд хийх дасгал, эмийн бодисыг бие махбодид хэрэглэх заавар зөвлөмж, сургалт,
14. Настны сувилахуй,

B.2. Гэрийн сувилахуйн тусламж, үйлчилгээ авах үйлчлүүлэгчийн заалт

1. Төрийн ба хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж байгаа бүх насны эрүүл хүмүүс,
2. Эрүүл мэндийн IV ба V – аар бүлэгт байгаа үйлчлүүлэгч,



B.3 Гэрээр сувилахуйн тусламж үзүүлэх мэргэжилтэнд тавигдах ерөнхий шаардлага

B 3.1 Мэргэжилтний эзэмшвэл зохих чадвар:

1. Сувилахуйн гардан үйлдлийн ур чадвар,
2. Сэтгэн бодох, шийдвэр гаргах чадвар,
3. Сурган заах арга зүйн чадвар,
1. Харилцааны чадвар (гэрийн хүмүүс, үйлчлүүлэгчтэй харилцах, гэрийн эздийн зөвшөөрлөөр эд юмтай ажиллах, хүний яриаг анхааралтай сонсох, хүлээн авах чадвар)
2. Багаар ажиллах чадвар, удирдан зохион байгуулах, төлөвлөх, дэмжих, хамт олноо хөгжүүлэх, хянах,
3. Сувилахуйн орчин үеийн техник, тоног төхөөрөмжтэй ажиллах чадвар,

B 3.2 Мэргэжилтний эзэмшвэл зохих хандлага:

1. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг баримтлах,
2. Сувилахуйн мэргэжлийн өвөрмөц ёс зүйг эзэмшсэн,
3. Үзүүлж байгаа тусламж, үйлчилгээнд бүтээлч, мэргэжлийн үүднээс хандах хандлагыг төгс эзэмшсэн,
4. Хүнлэг энэрэнгүй, хүний төлөө гэсэн чин сэтгэлтэй,
5. Өөрийгөө байнга хөгжүүлж, сурч боловсрох эрмэлзлэлтэй.

B3.3 Ёс зүйн болон хууль зүйн чадвар:

1. Сувилагч гэрийн нөхцөлд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг эрхэмлэнэ.
2. Сувилагч нь гэрээр тусламж үзүүлэхдээ хууль, эрх зүй, зохих журмыг баримтлан, эмнэлгийн ажилтны ёс зүйг эрхэмлэнэ
3. Үйлчлүүлэгч, ойр дотны хүндээ ч яриагүй зүйлийг сувилагчид итгэн ярьдаг учир итгэлийг нь хүлээн хувийн нууцыг хадгална
4. Мэргэжлийн багийн гишүүдийн хүлээх үүргийг тодорхой болгож, тусламж, үйлчилгээг зохицуулна
5. Өвчний янз бүрийн шатанд байгаа хүмүүс, хүүхэд, бэлэвсрэн хоцорсон хөгшид болон амьдралын эцсийн шатанд байгаа өвчтөний эрхийг хамгаалж, шаардлагатай арга хэмжээг үйлчлүүлэгчийн хүсэлтэд нийцүүлэн зохицуулж ажиллана.

B.3.4 сувилагчийн хүлээх хариуцлага

- Гэрээр тусламж үзүүлэх сувилагч нь Гэрийн нөхцөлд байгаа нярай болон бага наасны хүүхэд, эхчүүдэд эрүүл мэндийн тусламж, мэс заслын дараах өвчтөн, бэртэл гэмтэлтэй хүн, архаг хүнд өвчтэй болон амьдралын эцсийн шатанд байгаа хүнд сувилахуйн төрөлжсөн тусламж, үйлчилгээ үзүүлэх, хүн амын эрүүл мэндийн ба амьдралын чанарыг сайжруулахын төлөө хариуцлага хүлээн ажиллана.
- Төвөөс алслагдсан газар, баг, сум, эмчгүй газарт ажиллаж байгаа сувилагч нь зөвлөгөө авах, мэргэжлийн бусад хүмүүстэй зөвшилцэх боломж хомс байдаг тул бие даан шийдвэр гаргаж, үзүүлсэн тусламждаа хариуцлага хүлээнэ.
- Гэрийн сувилагч нь үйлчлүүлэгч, түүний гэр бүлийнхний өмнө мэргэжлийн зүгээс хариуцлага хүлээнэ.
- Сувилагч үзүүлсэн тусламж, үйлчилгээнд хариуцлага хүлээх үүднээс Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан сувилахуйн түүхийг үнэн зөв хөтлөх, хөтөлсөн түүхийн хуудсыг хадгалах, хамгаалах хариуцлага хүлээнэ.

B.3.5. Сувилагчийн хүлээх үүрэг

- Үйлчлүүлэгчид үзүүлэх тусламжийг төлөвлөх, хянах, дүгнэлт, шийдвэр гаргах,
- Гэртээ байгаа үйлчлүүлэгчийн нөхцөл байдал (орчин, хоололт, хувцаслалт, сэтгэл зүй, шинж тэмдэг, өөрийгөө асрах чадвар)-ыг үнэлж, тэднийг дэмжих, хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, цогц тусламж (holistic care) үзүүлэх, тэдэнд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх үүрэгтэй,
- Хурц ба архаг өвчтэй хүний эрүүл мэндийн байдлыг үнэлэх, сувилгааны онош тавих, төлөвлөх, тусламж үзүүлэх, үзүүлсэн тусламждаа дүгнэлт гаргах үүрэгтэй,
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг бүрэн эзэмшсэн, үйлчлүүлэгчтэй холбоотой ямар нэгэн асуудалд мэргэжлийн үүднээс хандах үүрэгтэй /хувийн харилцаа үүсгэхээс сэргийлэх/ ,
- Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламжийн талаарх нотолгоонд суурилсан судалгаа хийх үүрэгтэй,
- Шинжилгээ захиалах (цус, шээс г.м), унших, эрсдэлтэй үед эмчилгээний багийнхантай хамтран ярилцах, санал солилцож, шийдвэр гаргаж ажиллах үүрэгтэй,
- Эмчлэгч эмчийн заавраар болон өвчний намжмал үед эмийн болон бусад эмчилгээний зохицуулалт хийх үүрэгтэй.

B.3.6 сувилагчийн эрх:

- Үйлчлүүлэгч, ар гэрийнхэн, холбогдох хүмүүстэй уулзаж сувилахуйн тусламж, үйлчилгээний асуудлаар зөвшилцэх, хамтарч шийдвэр гаргах эрхтэй.
- Үйлчлүүлэгч, тэдний ар гэрийнхэн, асран хамгаалагчдад эрүүл мэндийн боловсрол олгох эрхтэй.
- Гэрээр сувилахуйн тусламж үзүүлэх сувилагч нь аюулгүй орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлэх эрхтэй. Үүний тул эхлээд орчны үнэлгээг хийсэн байх шаардлагатай.
- Гэр бүлийн гишүүдийн зүгээс, мэргэжлийн бус тусламж авахыг хүсэх, мэргэжлийн бус хэлбэрийн үйл ажиллагаанд оролцохыг /баяр тэмдэглэх, согтууруулах ундаа

хэрэглэх/ албадах тохиолдолд сувилагч, тусlamж, үйлчилгээ үзүүлэхийг зогсоох эрхтэй.

5. Хэрэв сувилагчийн амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөл, байдал үүсвэл биеэ хамгаалах эрхтэй.
6. Аюултай буюу эргэлзээтэй гэж үзвэл орон нутгийн цагдаа болон аюулгүй албаны ажилчдыг дагуулж явах боломжийг бүрдүүлж ажиллана.

B.4 сувилагчийн гэрээр үзүүлэх тусlamж, үйлчилгээний жагсаалт

B.4.1 ерөнхий сувилахуйн тусlamж, үйлчилгээ

- B.4.1.1 Халуун үзэх,
- B.4.1.2 Судасны цохилт, амьсгал тоолох
- B.4.1.3 артерийн даралт хэмжих
- B.4.1.4 Биеийн өндөр, жин үзэх
- B.4.1.5 Бумба тавих
- B.4.1.6 Гич наах
- B.4.1.7 Халуун, хүйтэн жин тавих
- B.4.1.8 Халуун, хүйтэн бигнүүр тавих
- B.4.1.9 Өвчинөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж өгч биечлэн үзүүлэх сургалт, сурталчилгааг гэрийн нөхцөлд явуулах

B.4.2 Төрөлжсөн сувилахуйн тусlamж, үйлчилгээ


Нярайн сувилахуй

- B.4.2.1 Няraig усанд оруулах
- B.4.2.2 Нярайн хүй цэвэрлэх
- B.4.2.3 Нүд, чих, хамар цэвэрлэх,
- B.4.2.4 Нярайн хоол тэжээлийн талаар зөвлөмж өгөх,
- B.4.2.5 Няraig жинлэх, урт өндрийг хэмжих,
- B.4.2.6 Нярайн ерөнхий асаргаа, сувилгаа, хяналтын талаар зөвлөмж өгөх.

2.1 Хүүхдийн сувилахуй

- B.4.2.7 Хүүхдийн эрүүл мэндэд амьдрах ба, хүрээлэн буй орчны нөлөөний талаар зөвлөмж, сургалт, мэдээлэл
- B.4.2.8 Сул сонсголтой, хэл ярианы бэрхшээлтэй хүүхдэд хийх дасгал, зөвлөмж өгөх,
- B.4.2.9 Бие, физиологийн өсөлтийн сааталтай хүүхдэд хийх дасгал, зөвлөмж өгөх,
- B.4.2.10 Хүүхдийн хоол тэжээл, хэмжээ, тэжээллэг чанар, өдрийн хоолны цэс, хоололтод анхаарах, зөвлөмжлэх,
- B.4.2.11 Хүүхдийн өдрийн дэглэм, цаг хуваарилалт, хүүхдийн гэрийн асаргааны зарчмуудыг эцэг эхэд биечлэн үзүүлж сургах
- B.4.2.12 Шингэн сэлбэх, давсны уусмал бэлдэж уулгахыг заах

B.4.2.13 Ханиад шуухинаа суулгалтын үед гэрээр уулгах эмүүдийн тун хэмжээг эмчийн заалтын дагуу хэрхэн уулгахыг заах



2.2 Насанд хурэгчдийн сувилахуй

B.4.2.14 Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүнд хийх дасгал, зөвлөмж

B.4.2.15 Нүд, чих, хамар хоолойд эмийн бодис хэрэглэх, заавар зөвлөмжөөр хангах

B.4.2.16 Цэвэрлэх болон тэжээлийн бургуй тавих

B.4.2.17 Давсаг угаах, шээлгүүр тавих,

B.4.2.18 Үтрээний угаалга, үтрээнд цацлага цацлага хийх

B.4.2.19 Үтрээнээс наалдцын шинжилгээ авах,

B.4.2.20 Өтгөн хаталтад үнэлгээ өгөх,

B.4.2.21 Өтгөн хаталтад авах арга хэмжээг төлөвлөх,

B.4.2.22 Төрөл бүрийн шарх цэгцлэх, оёдол авах, боолт хийх

B.4.2.23 Цэвэр боолт солих

B.4.2.24 Гэмтэл, бэртэлт, цус алдалтын үед авах анхны тусламж,

B.4.2.25 Саажилттай өвчтөнд нөхөн сэргээх дасгал, хөдөлгөөн зааж сургах,

B.4.2.26 Татлага хийх,

B.4.2.27 Эмчилгээний биеийн тамирын дасгал заах, хийлгэх,

B.4.2.28 Төрөлтөд бэлтгэх дасгал хийлгэх, заах, хөх арчлах, төрсний дараах асаргаа.

Өндөр настан, хэвтрийн хүнд өвчтөнд гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж

B.4.2.29 Хүнд өвчтөнд хийх асаргаа сувилгааны талаар гэр бүлийн гишүүдэд зөвлөлгөө өгөх, сургалт сурталчилгаа хийх

B.4.2.30 Биеийн хөшингө гаргах, иллэг, бария,

B.4.2.31 Биед хэсэгчилсэн иллэг хийх

B.4.2.32 Бүх биеийн иллэг хийх

B.4.2.33 Рефлекс сэргээх дасгал хийх

B.4.2.34 Тосон болон сүүн бария

B.4.2.35 Цэр ховхлох иллэг, утлага

B.4.2.36 Цэрийг механик аргаар гаргах

B.4.2.37 Гэдэс дүүрэлтийг намдаах даралтат иллэг

B.4.2.38 Хүчилтөрөгчийн холимог бэлтгэх

B.4.2.39 Жин хасах дасгал заах, хийлгэх

B.4.2.40 Бүх биеийн угаалга хийх

B.4.2.41 Толгойг угаах, үс самнах, усанд оруулах,

B.4.2.42 Хэсэгчилсэн угаалга хийх

B.4.2.43 Амны хөндий арчлах

B.4.2.44 Ор цэвэрлэх, орны цагаан хэрэглэл солих,

B.4.2.45 Хувцаслах

B.4.2.46 Нурагт, холголт, цооролтоос сэргийлэх сувилахуйн тусламж

- B.4.2.47 Хэвтрийн өвчтөнийг хооллох, өвчтөнийг орноос буулгах, түшлэгтэй сандалд суулгах, бие засах газар, хөтөвчинд суулгах,
- B.4.2.48 Хүнд өвчтөнд сэтгэл засал хийх
- B.4.2.49 Хэвтрийн байрлал өөрчлөх, хагас суугаа байрлалд суулгах унаж, бэртэхээс сэргийлэх арга хэмжээ авах,
- B.4.2.50 Тахир дутуугийн тэргэнцэр хэрэглэж сургах, хөтөвч тавих,
- B.4.2.51 Нэг удаагийн ариун цэврийн хэрэглэл солих \памперс, тампон),
- B.4.2.52 Нэг удаагийн ариун цэврийн хэрэглэлийн арчилгаа \колопласт, иелопласт, шээлгүүр\
- B.4.2.53 Ухаангүй өвчтөнд сувилгаа хийх
- B.4.2.54 Өвчтөн амирлах үед сувилгаа хийх, гэр бүлийн гишүүдийн зовлонг нимгэлэх, сэтгэл санааны сувилгаа
- B.4.2.55 Гэр бүлийн гишүүдэд, хэвтрийн хүнд өвчтөнийг асрахад сургах
- B.4.2.56 Эрүүл мэндийн сургалт сурталчилгаа хийх

B.4.3 Эмчийн заалтаар гэрийн нөхцөлд үзүүлэх тусламж, үйлчилгээ.

- B.4.3.1 Судсанд тариа хийх
- B.4.3.2 Булчин, арьсан дор, арьсан дотор тариа хийх
- B.4.3.3 Шингэн юүлэх
- B.4.3.4 Ходоод хаймсуурдах, угаах (эмчтэй хамтран)
- B.4.3.5 Цөсний хүүдий хаймсуурдах, угаах (эмчтэй хамтран)
- B.4.3.6 Цөсний хүүдий механикаар угаах (эмчтэй хамтран)
- B.4.3.7 Цус, шээсний ерөнхий шинжилгээ авах
- B.4.3.8 Зүрхэнд шууд иллэг хийх
- B.4.3.9 Шулуун гэдсээр эм хэрэглэх
- B.4.3.10 Дуслаар тэжээх, хооллох
- B.4.3.11 Бургуй тавих,
- B.4.3.12 Бумба,гич хэрэглэх,

B.5. БҮРТГЭЛ ХЯНАЛТ

- Сувилагч үзүүлсэн тусламж, үйлчилгээндээ хариуцлага хүлээх үүднээс үйлчилгээ үзүүлсэн үйлчлүүлэгч бүрт Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан сувилахуйн анхан шатны маягтыг үнэн зөв хөтлөх, хөтөлсөн хуудсыг хадгалах, хамгаалах хариуцлага хүлээнэ.
- Тусламж үйлчилгээ үзүүлсэн сувилагч өөрөө болон, хөндлөнгийн байгууллагаас хийсэн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа нь тусламж, үйлчилгээний чанарыг нотлох гол шалгуур байна.
- Сувилгааны үр дүнг багаар хэлэлцэж, цаашид авах арга хэмжээг төлөвлөх, хамтарсан шийдвэр гаргаж ажиллах зарчим баримталж ажиллана.
- Гэрээр тусламж үзүүлсэн сувилгааны хэрэгжилтэнд тухайн багийн ахлагч, ахлах сувилагч, сувилгааны алба, чанарын алба хяналт тавьж, үр дүнг сар бүр тооцож,

харьяа байгууллагын хагас, бүтэн жилийн тайланд тусган, хэлэлцүүлж үр дүнг байнга тооцож ажиллана.

ХАВСРАЛТ 1. Гэрийн сувилахуйн тусlamж, үйлчилгээ үзүүлэх сувилагчийн ажлын байрны тодорхойлолт /үлгэрчилсэн загвар/

№	Нийтлэг үндэслэл	Тавигдах шаардлага
1	Ажлын байр	Өрх, сумын эрүүл мэндийн төв, II, III шатлалын эмнэлэг, “Гэрээр сувилахуйн тусlamж үзүүлэх баг” бусад төрлийн баг, Сувилал, асрамжийн газар, хөнгөвчлөх эмчилгээний газар,
2	Ажлын туршлага	Эрүүл мэндийн байгууллагад 5-10 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх;
3	Боловсролын зэрэг	Дипломын, Бакалавр ба түүнээс дээш
4	Үндсэн үүрэг	Гэрээр үзүүлэх сувилахуйн тусlamж үйлчилгээний удирдамжид заасан үүрэг, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, Гэртээ байгаа үйлчлүүлэгчид (хурц ба архаг өвчтэй хүнд) сувилгааны үйл ажиллагааны 5 шатлалын дагуу тусlamж, үйлчилгээ үзүүлэх, Эрүүл мэндийн боловсрол олгох, сургах, Үйлчлүүлэгчийн хувийн нууцлалыг хадгалах, Гэрээр үзүүлэх сувилахуйн тусlamжийн талаарх нотолгоонд суурилсан судалгаа хийх, Багийн бусад гишүүдтэй хамтран ажиллах
5	Цаашид тавигдах шаардлага	Тасралтгүй суралцах эрмэлзлэлтэй; Гэрээр үзүүлж буй сувилахуйн тусlamжийн асуудалд дүн шинжилгээ, судалгаатай ажиллах арга зүй эзэмшсэн байх; Магистр ба түүнээс дээш зэрэгтэй бол (шаардлагатай тохиолдолд) эмийн жор бичдэг байх; Машин жолоодож (хөдөө орон нутагт энгийн хөсөг /морь, тэмээ/ унаж чаддаг байх) гэх мэт

ХАВСРАЛТ 2. Гэрээр тусламж үзүүлэх сувилагчийг мэргэшүүлэн сургах загвар

Ерөнхий боловсролын сургууль төгссөн суррагч сувилагч мэргэжлээр туслах, дипломын, бакалавр гэсэн 3 чиглэлээр суралцах боломжтой бөгөөд туслах сувилагчийн ба дипломын ангид “Гэрийн сувилахуй” хичээлийн агуулга тус бүр 1 кредит, харин бакалавр сувилагчийн ангид 2 кредит байх нь тохиромжтой гэж үзлээ. Хичээлийн агуулгад гэрийн сувилахуйн тусламж, гэрийн сувилагчийн үүрэг хариуцлага, бичиг баримт хэрхэн хөтлөх, хийсэн ажлын тэмдэглэл, ба нийтлэг мэдээлэл гэсэн ерөнхий агуулгыг багтаасан байх юм. Төгсөж гарсан сувилагч гэрийн нөхцөлд эмч, магистр сувилагчийн заалтаар анхан шатны тусламж үзүүлнэ.

Магистр ба докторын сургалтанд сонгон суралцах 2-4 кредитийн хичээлээр үйлчлүүлэгчид өндөр түвшинд, эрүүл мэндийн үнэлгээ хийх мэдлэг, чадвар, хандлага олгож, патоанатоми, патофизиологи, эм судлал, эрүүл мэндийн судалгаа, эрүүл мэндийн бодлого, эдийн засгийн онол, мэргэжлийн мөн чанар, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах талаарх мэдлэг эзэмшүүлэх ба гэрийн нөхцөлд төрөлжсөн мэргэжлийн тусламжийг бие даан үзүүлж, эмчтэй нэгэн баг болж ажиллана.

Төгсөлтийн дараах “Гэрийн сувилагч”-ийн мэргэжил эзэмшүүлэх 12-15 кредитийн, 6 сар ба түүнээс дээш хугацааны сургалтаар үйлчлүүлэгчид эрүүл мэндийн судалгаа, төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, өвчин тус бүрээр сувилахуйн тусламж үзүүлэх мэдлэг, чадвар эзэмшүүлж, зөв хандлага төлөвшүүлнэ. “Гэрийн сувилагч”-аар мэргэшсэн сувилагч эмчгүй газар, сувилахуйн чиглэлээр төрөлжсөн мэргэжлийн тусламж үзүүлэх боломжтой байх юм.

B.5.1. Гэрийн сувилахуй хичээлийн хөтөлбөрийн хувилбар

“Гэрийн сувилахуй” хичээлийн агуулгад өөрчлөлт оруулахдаа, эрдэмтэн “Рональд Харден”-/тайлбар оруулах/ий аргыг үндэслэн, Монгол орны нөхцөл, зонхилон тохиолддог зарим эмгэгийг харгалзан, гэрээр тусламж үзүүлж буй сувилагч дараах мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшсэн байх нь зүйтэй.

Мэргэжилтний Эзэмшвэл Зохих Мэдлэг:

1. Шинжлэх ухааны судалгаа шинжилгээний арга зүй
2. Патоанатоми (гүнзгийрүүлсэн түвшинд)
3. Патофизиологи (гүнзгийрүүлсэн түвшинд)
4. Бодисын солилцоо
5. Дархлаа судлал
6. Лаборатори
7. Клиник эм судлал
8. Сэтгэл зүй
9. Сувилгааны үйл ажиллагаа (гүнзгийрүүлсэн түвшинд)

10. Сэтгэн бodoх, шийдвэр гаргах арга зүй II
11. Эрүүл ба өвчтэй байх зан үйл
12. Хоолоор сувилахуй
13. Гэрийн сувилахуй (Гэрийн сувилахуйн талаарх ерөнхий ойлголт, хөгжсөн түүх, гэрийн сувилагч болон мэргэжлийн багийн онцлог, үйлчлүүлэгч, тэдний сэтгэл зүйн онцлог, гэрээр сувилгаа хийхийн өмнөх бэлтгэл, үүрэг, ЭМС-ын тушаал, журам, бичиг баримт хөтлөлт)
14. Хүүхдийн сувилахуй I, II, III, IV
15. Насанд хүрэгсдийн сувилахуй I, II, III, IV
16. Настны сувилахуй
17. Хавдартай өвчтөний сувилахуй
18. Сэтгэцийн сувилахуй
19. Яаралтай тусlamж
20. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй

Мэргэшүүлэн сургах:

1. Өрхийн сувилахуй
2. НЭМ-ийн сувилахуй
3. Хамт олны сувилахуй
4. Сувилахуйн удирдлага, зохион байгуулалт
5. Сувилахуйн судалгаа

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. “Гэрээр үзүүлэх сувилахуйн тусlamж, асаргаа, сувилгаа хийх журам” Эрүүл мэндийн сайдын 2004 оны 136 дугаар тушаал,
2. “Сувилахуйн тусlamж, үйлчилгээг хөгжүүлэх стратеги” Эрүүл мэндийн сайдын 2012 оны 272 дугаар тушаал,
3. Sherry L, Catherine M. The Nursing Clinics of North America. Home Health Care. New York. 1988, p. 6, 315.
4. American Nurses Association. Standards of home health nursing practice. Kansas City, MO: The Association, 1986. <http://www.hhna.org/>
5. Graeme Edmond. Auckland Health Care. New Zealand: 2001. p. 8.
6. Miao-Chin Chen., Chin-Guan Lee. The Nursing Policy in Taiwan. International Workshop of Nursing Leadership and Management; 2007 Oct 12-18; Leeds China. Taiwan: Springer 2007.
7. Оргил Б., Мухар Ц., Баасанжав Н., Малчинхүү Д., Шижирбаатар Б. Өрхийн эмчийн тусlamж, үйлчилгээ. I боть. Улаанбаатар: Шувуун саарал; 1997. x. 9-10.
8. Lisa Yarkony. Caring. 2012 march; p 28: www.nahc.org/CARINGMagazine/nurses.html

9. Judd, Deborah. A History of American Nursing. Trends and Eras. USA, New York: 2009. p. 272. www.navigation.com
10. Kalisch, Philip Arthur, Beatrice J, Kalisch. The Advance of American Nursing. 2nd ed. USA, New York: 1986. www.navigation.com
11. International Council of Nurses. Nurse Practitioner/Advanced Practice Nurse: Definition and Characteristics. Nursing Matters Fact Sheets. Retrieved. 2011 Dec.
12. American Nurses Association. Nursing Fact: Today's Registered Nurse-Numbers and Demographics. Washington: D.C; 2006.
13. United Kingdom Government. Nurses Midwives and Health Visitors Act. London: HMSO; 1997.
14. Lusia, Patricia R, Otto, Tammy E, Patrick A. Reviews of Human Factors and Ergonomics. Chapter 1. Performance in Nursing. USA: 2009. p. 1-40.
15. Conrad C.F, Haworth J.G, Millar S.B. A Silent Success Master's Education in the United States. Baltimore, MD: The Johns Hopkins University Press; 1993.
16. Ганбат Б. Анагаах ухааны боловсролын олон улсын стандартын хөгжил ба Монгол улс. Анагаах ухааны боловсрол судлал. Улаанбаатар: ЭМШУИС Эрхэс; 2009. x. 61.
17. Ronald M, Harden, John A. A Practical Guide For Medical Teachers. Sydney Toronto: 2001.
18. Отгонбаяр Д. Анагаахын сургалтын нэгдмэл хөтөлбөрийн үнэлгээний зарим асуудалд. Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол. Улаанбаатар: Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль; 2010. x. 22.
19. Уранчимэг Г. Сургалтын хэрэгцээг тогтоох үндсэн зарчмууд. "Нийгмийн эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох нь" сэдэвт семинарын илтгэлийн хураангуй. Улаанбаатар. 1999. x. 20-23.
20. Өлзийсайхан С. Эмнэлгийн мэргэжилтний резидентурын сургалтын стандарт. Улаанбаатар: Admon XXK; 2005. x. 143.
21. Бэгэ Н. Боловсрол ба хөгжил. Монголын боловсрол судлалын шинэ парадигм. Улаанбаатар: Соёмбо принтинг; 2011. x. 137.
22. Public Health Nursing. USA: O Blackwell Publishing; Inc. Vol. 19 No. 2, 0737-1209/02. 2006. p. 94-103.
23. Sachiyo Murashima, Satoko Nagata, Joan K. Magilvy, Sakiko Fukui, Mami Kayama. Home Care Nursing in Japan. 2002.
24. Joan K. Magilvy, Sakiko Fukui, Mami Kayama. Home Care Nursing in Japan. 2003.
25. Wu S, White A, Cash K, Foster S. Nursing home care for older people in Taiwan. Journal of Clinical Nursing, 2009 Jul; 18 (14).
26. Saxon S, Dassen T. Nurses knowledge and practice about urinary incontinence in nursing home care. Nurse Education Today. 2008 Nov. 28 (8): 976-34.
27. Chu LW, Chi I. Nursing homes in China. Journal of the American Medical Directors Association. 2008 May; 9 (4): 237-43.
28. Hickey E, Young J, Parker A, Czarnowski E. The effects of changes in nursing home staffing on pressure ulcer rates. Journal of the American Medical Directors Association. 2005 Jan-Feb; 6 (1): 50-3.

104

105

Эрүүл мэндийн сайдын
2013 оны **12** сарын **13** өдрийн
172-дугаар тушаалын
2 дугаар хавсралт

**“СУВИЛГААНЫ ГАЗАР”-т (NURSING HOME)-үзүүлэх сувилахуйн тусlamж,
үйлчилгээний удирдамж**

4. Товчилсон үгийн жагсаалт

- АД Артерийн даралт
БС Бакалавр сувилагч
ДС Дипломын сувилагч
МС Магистр сувилагч
ТС Туслах сувилагч
ХХК Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМБ Эрүүл мэндийн боловсрол
ЭМД Эрүүл мэндийн даатгал

5. Үндэслэл

Энэхүү удирдамжийг “Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолын хоёр дугаар хэсгийн: ...Эх хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх..., Нэг сувилагчид ногдох өвчтөний тоог олон улсын жишигт хүргэж, асаргаа, сувилгааны чанар, хүртээмжийг дээшлүүлэх... зорилтууд, “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолын 154-ийн 4-т заасан: “Сэтгэцийн өвчтэй, оюуны хомдолтой, хүнд хэлбэрийн сэтгэцийн эмгэгтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай асрамжийн газрыг бий болгоно” /ЭМЯ/ гэсэн заалтуудын хэрэгжилтийг хангах зорилгоор: “Сувилгааны газар”-т ажиллах сувилагчийн тусlamж, үйлчилгээний удирдамжийг боловсруулах зорилгоор хийв.

6. Оршил

Манай улсад урт хугацааны асаргаа сувилгаа шаардлагатай иргэд тухайлбал, хүнд, архаг, хэвтрийн өвчтөн, цус харвалт, мэс заслын дараах нөхөн сэргээлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэд тэдний гэр бүлийн, амьдралын чанарыг сайжруулах, сувилахуйн тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх нь тулгамдсан асуудал болсоор байна.

Урт хугацааны асаргаа, сувилгаа шаардлагатай иргэдийн асран хамгаалагчдын 77% нь асран хамгаалагчийн үүрэг гүйцэтгэж ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй, асран хамгаалагчдын 65.3%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна. Ажил хөдөлмөр эрхлэх 30-59 насны хүмүүсийн 51% нь асран халамжлагчийн үүрэг гүйцэтгэж байгааг эрдэмтдийн

судалгаа харуулж байна. Монгол гэр бүлийн онцлогийг судлан үзэхэд дараах дүгнэлт гарч байна.

Монгол гэр бүлийн онцлог

№	Гэр бүл	Эзлэх хувь
1	Уламжлалт гэр бүл 6-аас дээш ам бүлтэй, 2-3 үетэйгээ хамт амьдардаг, гэрээр хүнд өвчтөнийг асрах хүнтэй	30%
2	Орчин үеийн гэр бүл 4-5 ам бүлтэй, 1-2 үерээ хамт амьдардаг, гэрт буй хүнд өвчтөнийг гэрээр асрах боломж муутай	45%
3	Ирээдүйн гэр бүл 4-5 ам бүлтэй, хүнд өвчтөнийг гэрээр асрах боломж муутай	25%

Орчин үеийн болон ирээдүйн гэр бүл 70% -ийг эзэлж байгаа нь урт удаан хугацааны асаргаа сувилгаа шаардлагатай өвчтөнг асрах боломжгүй гэр бүлийн тоо нийгэмд ихсэж байна. Эмнэлэгт хэвтэх, эмнэлгийн тусlamж авахаас илүүтэй иргэнд ойрхон, гэрийн болон, байнгын асаргаа, халамж, хяналтанд байх хэрэгцээ өсч байна.


Манай хүн амын дунд энэ төрлийн тусlamж авах эрэлт, хэрэгцээ улам нэмэгдэж байгаа нь нэг талаас хүн ам зүйн хувьд дэлхий нийтээр насхилт нэмэгдэх, өвчлөлийн бүтэц өөрчлөгдөх, эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг авах уламжлалт орчин нөхцөл шинэчлэгдэж байгаатай холбоотой юм.

Дэлхийн улс орнуудын жишгээс үзвэл урт хугацаанд асаргаа, сувилгаа шаардлагатай иргэдэд үйлчлэх "Сувилгааны газар" буюу "Nursing home"-ийг байгуулан, эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний ачааллыг бууруулах, иргэдэд хүргэх эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлдэг туршлага нийтлэг байна.

Манай оронд халамжийн чанартай, асрамжийн цөөн байгууллага, олон улсын хандивын тусlamжтай "Хоспис"-ын үйл ажиллагана явуулдаг жижиг байгууллагууд байна. Эдгээр байгууллагуудад эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэх хэрэгцээ чухал байна. Манай орны хувьд урт, удаан хугацаанд сувилахуйн тусlamж, үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлдэг байгууллага, батлагдсан эрх зүйн баримт одоогоор байхгүй байна.

Иймээс насан туршдаа хүний асрамжинд байдаг болон удаан хугацаанд хэвтэрт байгаа хүмүүсийг хэвтүүлэн сувилах, мэргэжлийн тусlamж үзүүлэх шаардлагатай сувилгааны газар, түүнд ажиллах сувилагчийн тусlamж, үйлчилгээний удирдамж боловсруулав.

А. ЕРӨНХИЙ ХЭСЭГ



A.1. Тодорхойлолт

Сувилгааны газар (Nursing Home): Урт хугацаанд хэвтэн эмчлүүлэх, нөхөн сэргээх, асаргаа, сувилгаа шаардлагатай үйлчлүүлэгчид сувилахуйн тусlamж, үйлчилгээг мэргэжлийн түвшинд тасралтгүй үзүүлэх үйл ажиллагаатай эрүүл мэндийн байгууллагыг СУВИЛГААНЫ ГАЗАР гэнэ.

A.2 Өвчний код

Олон улсын өвчний ангиллын дагуу оношлогдож, эмчлэгдэж байгаа бүх үйлчлүүлэгчдийн сувилахуйн тусlamжийн хэсэгт ашиглагдана.

A.3. Удирдамжийг хэрэглэгчид

Удирдамжийг өмчийн олон хэлбэрийн Сувилгааны газарт ажиллах эрүүл мэндийн болон сувилахуйн тусlamж, үйлчилгээг үзүүлэгч сувилагч үйл ажиллагаандаа хэрэглэнэ.

A.4 Удирдамжийн зорилт.

- Үйлчлүүлэгчийн амьдралын хэрэгцээнд нийцсэн сувилахуйн тусlamж, үйлчилгээг үзүүлэх, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх
- Тусlamж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах
- Сувилахуйн тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх

A.5 Удирдамж боловсруулсан он.

- Боловсруулсан огноо: 2013 он

A.6. Шинэчлэн засах хугацаа:

Удирдамжийн хэрэгжилтийн байдлыг жил бүр байгууллагууд өөрийн үйл ажиллагааны хүрээнд үнэлэн, засвар оруулах саналаа ЭМЯ-ны Эмнэлгийн тусlamжийн хэлтэст ирүүлнэ. ЭМЯ-ны холбогдох газар хэлтэс засварыг оруулан 5 жил тутамд шинэчилнэ.

A.7 Удирдамж боловсруулахад оролцсон байгууллага, хүмүүсийн нэр, хаяг

Д.Солонго доктор,	ЭМШУИС, Сувилахуйн Сургуулийн багш, Сувилахуйн ухааны
Г.Хулан	ЭМШУИС, Сувилахуйн Сургуулийн багш, Сувилахуйн ухааны магистр, докторант,

10

Б.Булганцэцэг	"Ач" АУДС-ийн багш, Сувилахуйн Ухааны магистр,
Д.Одгэрэл	ЭМШУИС-ийн Сувилахуйн Сургуулийн багш, Сувилахуйн Ухааны магистр
С.Дүүриймаа	"Ач" АУДС-ийн багш, Сувилахуйн ухааны магистрант

Удирдамжийг хэлэлцүүлсэн байдал:

Хэлэлцүүлсэн байдал	Хугацаа/ Давтамж	Бүрэлдэхүүн
Төслийн ажлын хэсгийн хурал	26/IV, 16/V, 15/VI, 28/VI, 11/IX, 18/IX, 30/IX	Төслийн ажлын багийн хурлаар
Сувилахуйн мэргэжлийн салбар зөвлөлийн хурал	19/VIII, 17/IX	Сувилахуйн мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүд
ЭМЯ-ны эмнэлгийн тусlamжийн хэлтсийн хурал	4/VII, 27/IX	Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүд,
Зөвлөлдөх уулзалт	28/VIII	"Сувилахуйн тусlamж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулья" Тэргүүний сувилагчдын улсын зөвлөгөөн /250 сувилагч/

A.8 Нэр, томьёо, тодорхойлолт, эх сурвалж

A.8.1 Нэр, томьёо

Сувилгааны үйл ажиллагааны 5 шатлал

- Үнэлэх- мэдээлэл цуглуулах /асуумж авах, ажиглах, бодит үзлэг хийх/
- Оношлох – асуудлыг тодорхойлох
- Төлөвлөх- зорилгод хүрэх төлөвлөгөө боловсруулах
- Хэрэгжүүлэх- төлөвлөгөөг хэрэгжүүлэх
- Дүгнэх- Сувилгааны үр дүнг тооцох

Асаргаа, сувилгааны үндсэн зарчим

- Тав тухтай орчин бүрдүүлэх
- Зөв зохистой хооллох
- Цаг агаарт тохируулан хувцаслах
- Сэтгэл зүйд дэмжлэг үзүүлэх
- Шинж тэмдгийн асаргаа, сувилгаа

A.8.2 Тодорхойлолт

Ажлаа зөв оновчтой зохион байгуулахад чиглэгдсэн тодорхой дэс дараалалтай, хоорондоо уялдаа холбоо бүхий хүн нэг бүрт сувилахуйн тусlamжийг чанарын өндөр түвшинд тасралтгүй хүргэх, үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдалд бий болсон болон болзошгүй асуудлыг илрүүлж, шийдвэрлэгдэхэд чиглэгдсэн сувилахуйн мэргэжлийн үйл ажиллагаа юм.

A.8.3 Эх сурвалж.

- 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоол,
- Монгол улсын оношилгоо, эмчилгээний түгээмэл үйлдлийн MNS 4621:2008 стандарт,
- Эрүүл мэндийн сайдын 2004 оны 136 дугаар тушаал,

Б. СУВИЛГААНЫ ГАЗАРТ АЖИЛЛАХ СУВИЛАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭС ДАРААЛАЛ

Б. 1. Сувилгааны газарт үйлчлүүлэгчдэд үзүүлэх сувилахуйн тусlamж

Б. 1. 1. Сувилгааны хэсэгт ажиллах сувилагч нарын үйл ажиллагаа нь эмнэлгийн бүх тасаг, хэсгүүдэд баримтлах сувилгааны ерөнхий арга зүй болон тасгийн үйл ажиллагааны онцлогийг тусгасан анхан шатны бүртгэл маягт, удирдамж, стандартуудыг баримталж, түүнийг шууд дүрэм, мөрдлөг болгон ажиллахад чиглэгдэнэ.

Б.1.4 Сувилахуйн тусlamж, үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагаанд асаргаа, сувилгааны үндсэн зарчим дээр үндэслэн сувилгааны үйл ажиллагааны таван шатлалыг хэрэгжүүлнэ.

Б.1.6 Сувилагч үйлчлүүлэгчид үзүүлсэн тусlamж, үйлчилгээ, зөвлөгөөг сувилахуйн түүхэнд тэмдэглэнэ.

Б.1.7 Сувилагч анхан шатны хөтлөгдөх маягтыг энэхүү удирдамжид заасан маягтын дагуу хөтөлж тэмдэглэл хийнэ.

Б.1.8. Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчдийн өвчний онцлогт тохирсон \ өдөр тутмын үйл ажиллагаа болон бие даах чадварт үнэлгээ өгөх, тэргэнцэрт суулгах, босгох, туслах хэрэгслэлийг хэрэглүүлж сургах, сонсголын аппарат, таяг, протез, түшлэг, нэг удаагийн ариун цэврийн хэрэгслэл \катетр, стом\ - ийг арчлах, сольж сургах, дарагдлаас үүсэх шарх үүсэхээс урьдчилан сэргийлэх талаар зааж сургах\ асаргаа сувилгаа хийнэ.

Б.1.9. Осол гэмтлийн дараах үйлчлүүлэгчдийн өвчний онцлогт тохирсон \ өдөр тутмын үйл ажиллагаа болон бие даах чадварт үнэлгээ өгөх, өвдөлт үнэлэх, хянах, хүйтэн жин бигнүүр тавих, солих, үйлчлүүлэгчийг зөөх, тээвэрлэх, байрлал өөрчлөх, тэргэнцэрт суулгах, босгох, хэрэглүүлж сургах, туслах хэрэгслэлийг хэрэглүүлж сургах, сонсголын аппарат, таяг, протез, түшлэг, нэг удаагийн ариун цэврийн хэрэгслэлийг сольж сургах, дарагдлын шарх үүсэхээс урьдчилан сэргийлэх талаар өөрт нь болон асран хамгаалагчдад зааж сургах \ асаргаа сувилгаа хийнэ.

Б.1.10. Цус харвалтын дараах үйлчлүүлэгчдийн өвчний онцлогт тохирсон \ өдөр тутмын үйл ажиллагаа болон бие даах чадварт үнэлгээ өгөх, үйлчлүүлэгчийг зөөх, тээвэрлэх, байрлал өөрчлөх, бүтэн биеийн болон хэсэгчилсэн угаалга, иллэг массаж хийх, дасгал хөдөлгөөн хийлгэх, хооллох, бургуй тавих, салхилуулах, хэл засал, тэргэнцэрт суулгах, босгох, хэрэглүүлж сургах, туслах хэрэгслэлийг хэрэглүүлж сургах, сонсголын аппарат, таяг, протез, түшлэг, нэг удаагийн ариун цэврийн хэрэгслэлийг арчлах, сольж сургах, дарагдлын шарх үүсэхээс урьдчилан сэргийлэх талаар өөрт нь болон асран хамгаалагчдад зааж сургах, шарх үүссэн тохиолдолд цэвэрлэх, боолт хийх, үнэргүй байлгах \ асаргаа сувилгаа хийнэ.

Б.1.11. Эх, хүүхдийн тасагт үзүүлэх сувилахуйн тусламж

Хүүхдийн биеийн байдалд үнэлгээ өгөх, усанд оруулах, хамар, чих, нүд, хүй цэвэрлэх, жинлэж, урт өндрийг хэмжих, дулаацуулах, ерөнхий асаргааны талаар зөвлөмж өгөх, сул сонсголтой, хэл ярианы бэрхшээлтэй болон өсөлтийн сааталтай хүүхдэд хийх дасгал, зөвлөмж, хүүхдийн хоол, тэжээлийн зөвлөгөө, шингэн сэлбэх давсны уусмал бэлдэж уулгах, эцэг, эхэд зөвлөгөө өгч зааж сургана.

Б.1.12. Мэс заслын дараах үйлчлүүлэгчдийн өвчний онцлогт тохирсон \ өдөр тутмын үйл ажиллагаа болон бие даах чадварт үнэлгээ өгөх, шарх үнэлэх, боолт солих, цэвэрлэх, цэгцлэх, шархны өвдөлт үнэлэх, хүйтэн жин бигнүүр тавих, дулаацуулах, өтгөн шингэний гарц хянах, бургуй тавих, нэг удаагийн ариун цэврийн хэрэглэлийг солих, арчлах, оруулах болон гадагшуулах стомийн эргэн тойрны арьс арчлах, үнэр дарах, зааж сургах, байрлал өөрчлөх, бүтэн биеийн болон хэсэгчилсэн угаалга, дасгал хөдөлгөөн хийлгэх, хоолны талаар зөвлөгөө өгөх, хооллох, туслах хэрэгсэл, сонсголын аппарат, таяг, протез зэргийг хэрэглүүлж сургах\ асаргаа сувилгаа хийнэ.

Б.1.13. Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж

Гэрээр тусламж авах үйлчлүүлэгчийн талаарх мэдээлэлтэй танилцах, үйлчлүүлэгчтэй холбоо барих (очих цагаа тохирох, хэрэгцээтэй зүйлсийг мэдэж авах), хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэх, (асаргаа сувилгааны цүнх, бичиг баримт, сувилгааны карт), үйлчлүүлэгчийн гэрт очих, үнэлгээ өгөх, карт хөтлөх, үйлчлүүлэгчтэй хамтран шийдвэр гаргах, сувилгаа хийх, нэг үйлчлүүлэгчийг эдгэртэл (ямар нэг үр дүнд хүртэл) хэдэн удаа гэрт нь сувилгаа хийх төлөвлөгөө зохиох, хуваарийн дагуу сувилгаа хийж, тухай

бүр үр дүнг тооцох, хийсэн бүх ажилбараа сувилгааны картанд бичиж тэмдэглэх, шаардлагатай тохиолдолд эмч дуудах, баг болж ажиллана.

В. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОДОРХОЙЛОЛТ, АРГАЧЛАЛ

В.1 хамрагдах үйлчилгээний төрөл

- Эмийн эмчилгээ, сувилгаа
- Сэргээн засах эмчилгээ, сувилгаа /Хийн дасгал, биеийн тамир эмчилгээ, зүү эмчилгээ, бария засал, иллэг гэх мэт/
- Хагалгаанд орсоны дараа нөхөн сэргээх, хяналт шаардагдах тохиолдууд
- Эрүүл мэндийн боловсрол олгох (Зөв хооллолт, хөдөлгөөн, артерийн даралт, болон - цусан дахь сахарыг гэрээр өөрөө хянах гм)
- Үйлчлүүлэгчийн ар гэрийнхэнд сургалт явуулах (Эм тогтмол уух, хэвтрийн үйлчлүүлэгч, харвалтын дараах нөхөн сэргээх, бие даах чадварыг сайжруулах, хооллолт болон шингэний баланс тооцох, хэсэгчилсэн болон бүтэн биеийн угаалга..., гм)
- Хөгжлийн бэрхшээлтэй болон осол гэмтлийн дараах үйлчлүүлэгчдийн бие даах чадвар болон өөрийгөө асрах чадварт сургах, зөвлөгөө өгөх
- Хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ (тухайн төрөлжсөн эмнэлэгт үзүүлнэ)
- Настанд үзүүлэх тусламж, үйлчилгээ

В.2 үйлчлүүлэгчийг хүлээн авах заалт

- Үйлчлүүлэгчийн өвчин эмгэг нь амь насанд шууд аюул учруулахааргүй байх
- Үйлчлүүлэгч нь ухаангүй, маш хүнд, овrogын заалтгүй байх
- Үйлчлүүлэгч өөрөө асаргаа сувилгааны нөхцлийг ойлгож зөвшөөрсөн байх /зөвшөөрлийг өвчний түүхэнд хавсаргасан байна/
- Бага насны хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд эмчилгээний явцад байнгын асран халамжлагчтай байх, асран хамгаалагч нь зөвшөөрсөн байх /зөвшөөрлийг өвчний түүхэнд хавсаргасан байна/
- Үйлчлүүлэгчийн гэрээс эмнэлэг хүртэлх зайд 30 километрээс хэтрэхгүй байх бөгөөд 2 талын тээврийн асуудлыг үйлчлүүлэгч өөрөө шийдвэрлэсэн байх
- Үйлчлүүлэгч болон тэдний ар гэрийнхэн, асран халамжлагч холбоо барих утастай байх ба сувилах төвд ирснээс хойш өдөрт 1- ээс доошгүй удаа холбоо барьж, биеийн байдлын талаар мэдээлэл өгч, тэмдэглэл хийсэн байх
- Зөвлөгөө авахад асран хамгаалагч нь үйлчлүүлэгчийн өвчин эмгэгийн онцлог, тусламж, үйлчилгээний талаар хангалттай мэдээллийг авах.

В.2. СУВИЛАГЧИЙН БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Хүн, түүний үнэт зүйлсийг хүндэтгэн үзэх үзэлд суурилсан, орчин үеийн сувилахуйн шинжлэх ухааныг үндэслэгч Ф.Найтингелийн онолын үндэслэлийн дагуу үйлчлүүлэгчийн тэгш эрхийн зарчимд суурилсан, нийгмийн анги давхарга, баян ядуу,

арьс өнгө болон шашны итгэл үнэмшлээр ялгаварлан гадуурхах үзлээс ангид, хүнлэг, энэрэнгүй, ил тод, шударга, үйлчлүүлэгчийн нэр төр, хувийн нууцлалыг хүндэтгэх, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэх, хууль журмыг чанд мөрдөх зэрэг зарчмыг баримтална.

B.2.1. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг баримталж ажиллана.

B.2.2. Асаргаа сувилгааны үндсэн зарчмыг баримтлана.

- Орчин
 - Хооллолт
 - Хувцаслалт
 - Шинж тэмдгийн асаргаа, сувилгаа
 - Сэтгэл зүй
 - Өөрийгөө асрах чадвар
- B.2.3. Сувилгааны үйл ажиллагааны 5 шатлалын дагуу ажиллана
- Үнэлгээ өгөх
 - Сувилгааны онош
 - Сувилгааны төлөвлөгөө
 - Сувилгааг хэрэгжүүлэх
 - Дүгнэх

B.2.4. Сувилахуйн түгээмэл үйлдлийн стандарт MNS-4621:2008 баримталж ажиллана


B.3 СУВИЛАГЧИЙН ҮҮРЭГ

B.3.1. Магистр зэрэгтэй сувилагчийн гүйцэтгэх үүрэг

- Сувилахуйн газрын үйл ажиллагааг удирдан чиглүүлнэ
- Үйлчлүүлэгчийн биеийн байдалд үнэлгээ өгнө
- Сувилгааны үйл ажиллагааны 5 шатлалаар ажиллана
- Үйлчлүүлэгчид үүсч байгаа асуудлыг шийдвэрлэх талаар шийдвэр гаргана
- Сувилахуйн тусlamж, үйлчилгээтэй холбоотой үүрэг даалгавар өгөх, биелэлтийг хянах, ажил үүргийг дүгнэнэ
- Асаргаа сувилгааны талаар мэргэжлийн зөвлөгөө өгнө
- Үйлчлүүлэгч, тэдний гэр бүлийн гишүүдтэй харилцаа холбоотой ажиллах, үйлчлүүлэгчийн эрүүл мэндтэй холбоотой мэдээлэл өгнө
- Үйлчлүүлэгчийн талаарх асуудлыг хамтран шийдвэрлэнэ

B.3.2. Бакалавр сувилагчийн гүйцэтгэх үүрэг

- Үйлчлүүлэгчийн биеийн байдалд үнэлгээ өгнө



113

- Сувилгааны үйл ажиллагааны 5 шатлалыг баримтлан ажиллана
- Магистр сувилагчийн удирдлага дор ажиллана
- Магистр сувилагчаас зөвлөлгөө авна
- Дипломын сувилагч болон сувилагчийн туслахад үүрэг даалгавар өгнө
- Үүрэг даалгаврын биелэлтийг хянана
- Үйлчлүүлэгчид үүсч байгаа асуудлыг шийдвэрлэх талаар шийдвэр гаргана
- Хийх асаргаа сувилгааг төлөвлөнө
- Асаргаа сувилгааны гардан үйлдлийг гүйцэтгэнэ
- Хийсэн асаргаа сувилгааны талаар тэмдэглэл хөтөлнө
- Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт явуулна
- Өдөр тутмын үйл ажиллагаанд үнэлгээ өгч шаардагдах сувилахуйн тусlamжийг цаг тухайд нь гүйцэтгэнэ
- Үйлчлүүлэгчид байнгын хяналт тавьна
- Асаргаа сувилгааны талаар зөвлөлгөө өгнө
- Үйлчлүүлэгчийн гэр бүлийн гишүүдтэй харилцаа холбоотой байна
- Ар гэр бүлд мэдээлэл өгнө
- Үйлчлүүлэгчийн талаарх асуудлыг хамтран шийдвэрлэнэ

B.3.3. Дипломын сувилагчийн гүйцэтгэх үүрэг

- Магистр сувилагч болон бакалавар сувилагчийн удирдлага дор ажиллана
- Магистр сувилагч болон бакалавар сувилагчаас зөвлөлгөө авна
- Сувилагчийн туслахад үүрэг даалгавар өгнө
- Хамтран асаргаа, сувилгаа хийнэ
- Хийх асаргаа сувилгааг төлөвлөнө
- Асаргаа сувилгааны гардан үйлдлийг гүйцэтгэнэ
- Хийсэн асаргаа сувилгааны талаар тэмдэглэл хөтөлнө
- Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт явуулна
- Үйлчлүүлэгчид байнгын хяналт тавина
- Үйлчлүүлэгчийн ар гэр бүлийн гишүүдтэй харилцаа холбоотой байна
- Ар гэр бүлд мэдээлэл өгнө
- Үйлчлүүлэгчийн талаарх асуудлыг хамтран шийдвэрлэнэ

B.3.4. Туслах сувилагчийн гүйцэтгэх үүрэг

- Шүршүүрт оруулах, ваннанд оруулах, хэсэгчилсэн угаалга хийнэ
- Байрлал солих, арьс цэвэрлэнэ
- Үс угаах, самнана
- Шүд угаах, ам цэвэрлэнэ
- Нүд, чих цэвэрлэнэ
- Бие засахад нь туслана

- Хөтөвч тавих, шээлгүүр тавина
- Живх солино
- Босч суух, явахад нь туслана
- Хөдөлгөөн хийхэд зориулагдсан туслах хэрэгсэл дээр бага багаар нь дасгал хийлгэнэ
- Алхах болон тэргэнцэрээр явахад нь туслана
- Сэтгэл санаагаар нь дэмжинэ
- Тав тухтай байлгана
- Хооллох, эрсдэлт хүчин зүйлийг багасгана
- Дотоод сүлжээ, тэмдэгт гэрэл, хонх зэрэгт хариулна
- Амин үзүүлэлт үзэх, орох, гарах шингэний хэмжээг тооцно
- Цэвэрлэгээ, ариутгал, өвчтөний өрөөний тоос шороог цэвэрлэхэд хяналт тавина.



B.3.5. Хөдөлгөөн засалч, хэл засалч, нөхөн сэргээх сувилагч, хоол зүйч, нийгмийн ажилтан, сайн дурынхан, сувилагчийн туслах, эмч зэрэг олон мэргэжлийн баг ажиллана.

B.4. ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

Сувилах газарт ажиллах сувилагч, туслах сувилагч нь байгууллагын дотоод журам, эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг хэм хэмжээг сахин, технологийн алдаа, зөрчил гаргасан тохиолдолд хууль, журмын дагуу зохих хариуцлага хүлээнэ.

B.5. СУВИЛАГЧИЙН ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ

Гүйцэтгэх сувилагч:

МС – Магистр сувилагч

БС – Бакалавр зэрэгтэй сувилагч

ДС – Дипломын зэрэгтэй сувилагч

ТС – Туслах сувилагч

№	Сувилгааны үйлдлүүд	Хэн гүйцэтгэх
1.	Үйлчлүүлэгчийн өдөр тутмын үйл ажиллагааг үнэлэх \Katz scale, Lawton scale, Barthal scale\	МС, БС
2.	Үйлчлүүлэгчид үзүүлэх тусламжийг төлөвлөх	МС, БС
3.	Хэвтрийн өвчтнийг хөдөлгөх \Өвчтөнийг орноос буулгах, түшлэгтэй сандалд суулгах, жорлон хөтөвчинд суулгах, тагтан дээр салхилуулах\	ДС, ТС
4.	Унаж бэртэхээс сэргийлэх, арга хэмжээ авах	БС, ДС, ТС
5.	Үйлчлүүлэгчийг салхилуулах	ДС, ТС
6.	Үйлчлүүлэгчтэй тоглох	ДС, ТС
7.	Хэвтрийн өвчтөний байрлал өөрчлөх	ДС, ТС
8.	Хэвтрийн өвчтнийг тээвэрлэх	БС, ДС, ТС
9.	Тахир дутуугийн тэргэнцэр хэрэглэж сургах	БС, ДС, ТС
10.	Хувцас солих \дотуур гадуур\	БС, ДС, ТС
11.	Хувцас тайлах \дотуур, гадуур\	ДС, ТС
12.	Хувцас өмсгөх \дотуур гадуур\	ДС, ТС
13.	Хувцас угаалганд өгөх	ДС, ТС
14.	14Хувцас угаах	ДС, ТС
15.	Орны цагаан хэрэглэл солих	ДС, ТС
16.	Орны цагаан хэрэглэл угаалганд өгөх	ДС, ТС
17.	Орны цагаан хэрэглэл угаах	ДС, ТС
18.	Орны цагаан хэрэглэл индүүдэх	ДС, ТС
19.	Ор цэвэрлэх	ДС, ТС
20.	Нэг удаагийн ариун цэврийн хэрэглэл солих \памперс, тампон\	БС, ДС, ТС
21.	Нэг удаагийн ариун цэврийн хэрэглэл тавих \колопласт, иелопласт, шээлгүүр\	БС, ДС
22.	Нэг удаагийн ариун цэврийн хэрэглэл солих \колопласт, иелопласт, шээлгүүр\	БС, ДС
23.	Нэг удаагийн ариун цэврийн хэрэглэлийн арчилгаа \колопласт, иелопласт, шээлгүүр\	БС, ДС
24.	Хэвтрийн өвчтний бүтэн биеийн угаалга	ДС, ТС
25.	Хэсэгчилсэн угаалга \шүд, ам, нүүр, бэлэг эрхтэн\	ДС, ТС
26.	Толгой угаах	ДС, ТС
27.	Үс самнах	ДС, ТС

28.	Усанд оруулах	ДС, ТС
29.	Хөтөвч тавих	ДС, ТС
30.	Шээс задгайрсан үед авах сувилахуйн тусламж	БС, ДС, ТС
31.	Давсганд шээлгүүр тавих	БС, ДС
32.	Давсаг угаах	БС, ДС
33.	Үтрээний толиор үзлэг хийх	БС, ДС
34.	Үтрээнээс наацын шинжилгээ авах	БС, ДС
35.	Өтгөн хаталтанд үнэлгээ өгөх	МС,БС
36.	Өтгөн хаталтанд авах арга хэмжээний талаар төлөвлөгөө боловсруулах, бичих	МС,БС
37.	Цэвэрлэх бургуй тавих	ДС, ТС
38.	Тэжээлийн бургуй тавих	ДС, ТС
39.	Бичил бургуй тавих	ДС, ТС
40.	Өтгөн задгайрсан үед үзүүлэх тусламж	БС, ДС, ТС
41.	Хий гаргах гуурс тавих	БС, ДС, ТС
42.	Бумба тавих	БС, ДС, ТС
43.	Гич хэрэглэх	БС, ДС, ТС
44.	Утлага хийх	БС, ДС, ТС
45.	Хооллоптын бэрхшээлтэй өвчтнийг үнэлэх	МС,БС
46.	Авах арга хэмжээний талаар төлөвлөх	МС,БС
47.	Залгихад бэрхшээлтэй өвчтөнийг хооллох	БС, ДС, ТС
48.	Хамар, ходоодны хаймсуур тавих	БС, ДС
49.	Хаймсуураар, гастростомоор хооллох	БС, ДС, ТС
50.	Хамар-ходоодны хаймсуур арчлах \цэвэрлэх\	БС, ДС, ТС
51.	Шулуун гэдсээр хооллох	БС, ДС, ТС
52.	Ходоод угаах	БС, ДС
53.	Цөс угаах	БС, ДС
54.	Артерийн даралт үзэх	БС, ДС, ТС
55.	Судасны лугшилт тоолох	БС, ДС, ТС
56.	Амьсгал тоолох	БС, ДС, ТС
57.	Биеийн халуун хэмжих	БС, ДС, ТС
58.	Трахеостомийг арчлах	БС, ДС, ТС

59.	Цэр салс соруулах	БС, ДС
60.	Нүд, чих, хамар цэвэрлэх	БС, ДС
61.	Нүд, чих хамар, ам, залгиурыг угаах	БС, ДС
62.	Нүд, чих хамар, ам, залгиурт эм дусаах	БС, ДС
63.	Нүд, чих хамар, ам, залгиурт чихээс тавих	БС, ДС
64.	Халуун жин, бигнүүр тавих	ДС, ТС
65.	Хүйтэн жин, бигнүүр тавих	ДС, ТС
66.	Эм уулгах	БС, ДС, ТС
67.	Шулуун гэдсээр эм хэрэглэх	БС, ДС, ТС
68.	Арьс салстанд эмийн бодис хэрэглэх \шавших, угаах, түрхэх\	БС, ДС
69.	Арьсан доторх тарилга хийх	БС, ДС
70.	Арьсан дор тарилга хийх	БС, ДС
71.	Арьсан дор удаан хугацаагаар дусал хийх	БС, ДС
72.	Булчин тарилга хийх	БС, ДС
73.	Судас тарилга хийх	БС, ДС
74.	Дусал тарилга хийх	БС, ДС
75.	Дуслаар тэжээх, хооллох	МС,БС
76.	Төрөл бүрийн боолт хийх	БС, ДС
77.	Шарх цэгцлэх, боолт хийх	БС, ДС
78.	Хэвтрийн цооролтын эрсдлийн үнэлгээ хийх	МС,БС
79.	Хэвтрийн цооролтоос сэргийлэх, авах арга хэмжээ	БС, ДС, ТС
80.	Хэвтрийн цооролтонд арга хэмжээ авах \уе шатанд тохируулж\	БС, ДС
81.	Өвдөлтийн үнэлгээ хийх \Wong Baker pain scale\	МС,БС
82.	Өвдөлтөнд авах арга хэмжээний талаар төлөвлөх	МС,БС
83.	Өвдөлттэй өвчтөнийг тайвшуулах, хөдөлгөөнөөс шалтгаалдаг өвдөлтийг намдаах	БС, ДС, ТС
84.	Хиймэл амьсгал хийх	БС, ДС, ТС
85.	Зүрхэнд шууд иллэг хийх	БС, ДС, ТС
86.	Саажилттай өвчтөнд дасгал хөдөлгөөн зааж сургах	БС, ДС, ТС
87.	Толгой, хүзүүний иллэг, бария	БС, ДС, ТС
88.	Бүх биеийн иллэг, бария	БС, ДС, ТС

89.	Хоолойд хүйтэн жин тавих	БС, ДС, ТС
90.	Электрофорезоор эмчлэх	БС, ДС, ТС
91.	Гэрлэн ванн	БС, ДС, ТС
92.	Хүчилтөрөгчийн коктейль эмчилгээ	БС, ДС, ТС
93.	Искра аппаратаар эмчлэх	БС, ДС, ТС
94.	УВЧ аппаратаар эмчлэх	БС, ДС, ТС
95.	Парафин эмчилгээ	БС, ДС, ТС
96.	Зөгийн балтай татлага	БС, ДС, ТС
97.	Арьсны тууралт, нуралттай нярайн асаргаа сувилгаа	БС, ДС, ТС
98.	Нярайд хүчилтөрөгч өгөх, амьсгалын замыг чөлөөлж соруулах	БС, ДС, ТС
99.	Нярайн цээжинд доргиох ба тогших иллэг хийх	БС, ДС, ТС
100.	Нярай хүүхдээс шээлгүүрээр шээс авах	БС, ДС, ТС

B.6. ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ӨРӨӨНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

119

1. Хүлээн авах

- Үзлэгийн өрөө
- Тусгаарлах өрөө
- Ариун цэврийн өрөө
- Зөвлөгөө өгөх өрөө
- Хүлээлгийн өрөө
- Сувилагчийн пост
- Хувцас солих өрөө /үйлчлүүлэгчийн/



2. Эрчимт эмчилгээ:

- Хэвтүүлэх өрөө /4 ортой, хөшгөөр тусгаарлагдсан/
- Ариун цэврийн өрөө /угаах, асаргаа сувилгаа хийх/

3. Ариутгал

- Сувилагчийн бохир материал хүлээн авах өрөө /ценхтой/
- Сувилагчийн цэвэр материал хүлээлгэн өгөх өрөө /ценхтой/

4. Хувцас солих өрөө /эр, эм /

- / нийт сувилагч, туслах сувилагч, үйлчлэгч, бусад ажилчид /
- Хувцасны шүүгээ
- Сандал

5. Гал тогоо

- Хувцас солих өрөө /нийт ажилчдын /
- Хоол бэлтгэх өрөө
- Хоол хийх өрөө
- Хоол түгээх өрөө
- Хоол, хүнс хадгалах өрөө /том хөргөгчтэй, хөлдөөгчтэй /
- Хооллох өрөө /ажилчдын/
- Сав суулга угаах өрөө
-

Сэргээн засах эмчилгээний тасаг

6. Физик эмчилгээ :

- Сувилагчийн өрөө
- Эмчилгээний өрөө /багаж тоног төхөөрөмжтэй/
- Ариун цэврийн өрөө

7. Усан эмчилгээ:

- Хувцас солих өрөө /эр, эм/
- Сувилгааны өрөө / церкулярны душ,саун,бассейн /

8. Шавар эмчилгээ:

- Хувцас солих өрөө /эр, эм/
- Эмчилгээний өрөө / тусгаарлагч, хаалттай/
- Ариун цэврийн өрөө
- Душ /эр, эм/

9. Бария засал, бумба :

- Эмчилгээний өрөө, /тусгаарлагч, хаалттай/
- Ариун цэврийн өрөө

10. Зүү эмчилгээ:

- Эмчилгээний өрөө / тусгаарлагч, хаалттай/
- Ариун цэврийн өрөө
- Душ /эр, эм/

11. Парафин /лааны тос/ эмчилгээ:

- Парафин бэлтгэх өрөө
- Эмчилгээний өрөө / тусгаарлагч, хаалттай/
- Ариун цэврийн өрөө
- Душ /эр, эм/

12. Хурлын заал :

- / Иж бүрэн техник, тоног төхөөрөмжтэй /
- Сандал ширээтэй

13. Соёлын заал:

- Тайз
- Иж бүрэн техник, тоног төхөөрөмжтэй
- Сандал
- Хувцасны өлгүүрийн өрөө
- Тоглоомын хэсэг /шатар, даам, хөзөр, даалуу, ширээний теннис, гар бөмбөг гм /



14. Ахуй засал: / Иж бүрэн хэрэгсэлтэй /

- Эмчилгээний өрөө
- Ариун цэврийн өрөө

15. Хөдөлгөөн засал: / Иж бүрэн хэрэгсэлтэй/

- Эмчилгээний өрөө
- Ариун цэврийн өрөө
- 16. Алжаал тайлах өрөө / бүх төрлийн ном, сонин, сэтгүүлтэй /
- 2 тасалгаатай
- Телевизор, DVD тоглуулагчтай

17. Хөдөлмөр сувилгаа – цус харвалтын дараах

- Оёдол
- Цэцэг тарих
- Гар урлал

18. Тасаг тус бүр дараах зохион байгуулалттай байна.

- Үйлчлүүлэгчийн өрөө,
- Ариун цэврийн өрөө нь өрөө тус бүрийн үүдэнд байна
- Сувилагчийн пост
- Үзлэгийн өрөө
- Тариа, боолтын өрөө
- Эрүүл мэндийн сургалт зохион явуулах өрөө
- Зөвлөгөө өгөх өрөө

- Хувцас солих өрөө /үйлчлүүлэгчийн/
- Бэлтгэлийн өрөө /Цагаан хэрэглэл, хэрэглэгдэх материал хадгалах/
- ЭМБ олгох өрөө
- Заал /телевизор, буйдан, ном сэтгүүл гм /
- Ахлах сувилагчийн өрөө
- Бохир материал хадгалах өрөө



Байшингийн дээврийн тохижолт

Байшингийн дээврийг бусад орны нэгэн адил ашиглах нь зохистой гэж үзсэн.

Үүнд:

- Дээврийг хиймэл болон таримал мод, цэцэг тарьж зүлэгжүүлэх /
- Шалыг халтирахгүй материалаар хийх / резин наах/
- Хатаагчийг олноор байрлуулах
- Үйлчлүүлэгч салхилах сандал, ширээ, сүүдрэвч байрлуулах,
- Тэдэнд зориулсан тоглоомын талбайтай байх



АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж:

1. "Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж, асаргаа, сувилгаа хийх журам" Эрүүл мэндийн сайдын 2004 оны 136 дугаар тушаал
2. "Сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратеги" Эрүүл мэндийн сайдын 2012 оны 272 дугаар тушаал
3. Оргил Б. Өрхийн эмчийн тогтолцооны хөгжилд сувилахуйн тусламжийн үүрэг. Сувилахуй ба эрүүл өрх. Илтгэлийн хураангуй. Улаанбаатар 1998. х.3.
4. Оюунханд Р. Монгол улсын настнуудын өвчлөлийн тархалт, сэтгэц болон нийгмийн эрүүл мэндийн байдал. Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол. Улаанбаатар: Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль; 2011.
5. Наранчимэг С. Өрхийн сувилагчийн үйл ажиллагаа. Сувилахуй ба эрүүл өрх. Улаанбаатар: МӨНН; 1998. х. 10.
6. Нямдаваа П. Нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд. Улаанбаатар: Битпресс; 1996. х. 51.
7. Public Health Nursing. USA: O Blackwell Publishing; Inc. Vol. 19 No. 2, 0737-1209/02. 2006. p. 94-103.
8. Sachiyo Murashima, Satoko Nagata, Joan K. Magilvy, Sakiko Fukui, Mami Kayama. Home Care Nursing in Japan. 2002.
9. Joan K. Magilvy, Sakiko Fukui, Mami Kayama. Home Care Nursing in Japan. 2003.
10. Wu S, White A, Cash K, Foster S. Nursing home care for older people in Taiwan. Journal of Clinical Nursing, 2009 Jul; 18 (14).
11. Saxon S, Dassen T. Nurses knowledge and practice about urinary incontinence in nursing home care. Nurse Education Today. 2008 Nov. 28 (8): 976-34.
12. Chu LW, Chi I. Nursing homes in China. Journal of the American Medical Directors Association. 2008 May; 9 (4): 237-43.
13. Hickey E, Young J, Parker A, Czarnowski E. The effects of changes in nursing home staffing on pressure ulcer rates. Journal of the American Medical Directors Association. 2005 Jan-Feb; 6 (1): 50-3.
14. Reilly D J, Oermann M N. Clinical teaching in nursing education. 2nd ed. New York: St Louis; 1992.
15. Баярсайхан Д. Эрүүл мэндийн бодлогод нийгмийн эрүүл мэндийн асуудлыг авч үзэх нь. Эрүүл мэндийн удирдлага. Улаанбаатар: Шувуун саарал; 2000. х. 25-42.
16. Оргил Б. Монгол дахь өрхийн анагаах ухааны төлөвшлийн онцлог ба хэтийн төлөв. Анагаахын шинжлэх ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол. Улаанбаатар: Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль; 2003. х. 126-129.
17. Цэнгэлмаа Б. Улаанбаатар хотын өрхийн эмч нарын ажлын байрны тодорхойлолтыг боловсронгуй болгох асуудал. Анагаах ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол. Улаанбаатар: Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль; 1999.